

## 1.Тавигдах шаардлага

Хүснэгтэд заасан тавигдах шаардлагыг хангасан оролцогч дараах материалыг бүрдүүлж, ирүүлнэ. Үүнд:

№	Тавигдах шаардлага	Бүрдүүлэх материал
1	Нийгмийн ажлын мэргэжлээр бакалавр, магистраас доошгүй зэрэгтэй.	Дипломын хуулбар
2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.	/CV/ ажилласан болон мэргэшсэн байдлыг илтгэх
3	Хамт олны дунд нэр хүндтэй, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй.	Нэр дэвшүүлсэн байгууллагын тодорхойлолт эсхүл мэргэжлийн холбооны гишүүдийн хурлын протокол.
4	Нийгмийн ажлын арга зүй, онол практикийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах идэвхи, санаачлагатай, манлайлах ур чадвартай.	“Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн төлөв байдал, цаашдын хөгжилд оруулах хувь нэмэр” сэдвийн хүрээнд хийхээр төлөвлөж буй 3 ажлын саналыг тайлбарлан бичих. /1 нүүрэнд багтаах/

## 2.Сонгон шалгаруулалт

Үндэсний хороонд гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, соёл, спорт, аялал жуулчлал, залуучууд, хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа газар, хэлтсээс нийт 5, нийгмийн ажилтан бэлтгэдэг Их, дээд сургууль, мэргэжлийн нийгэмлэг, холбоодоос нийт 4, анхан шатанд ажиллаж буй нийгмийн ажилтнуудаас 6, нийт 15 гишүүн сонгон шалгаруулна.

Сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулж, зарыг албан ёсны цахим хуудсанд байршуулах ба нийгмийн ажил, үйлчилгээ явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудад мэдээлнэ.

Шалгаруулалтыг ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газар, ХГББХЕГ—ын албан хаагчдаас бүрдсэн баг үнэлж, зохион байгуулна.

## 3. Хугацаа

Сонгон шалгаруулалтын материалыг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийг дуустал хүлээн авч, 10-р сарын 18-ны өдөр сонгон шалгаруулж, үр дүнг шалгарсан 15 гишүүнд тусгайлан мэдээлнэ.